

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН
ХЭРЭГЖИЛТ 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР

2019.06.20

Булган аймаг

№	Зохион байгуулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин	Хугацаа	Хэрэгжилтийн явц
1	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулна	Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулах Ирсэн зөвлөмжийг байгууллагуудад хүргүүлэх Илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэл өгөх	Байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөлт сайжирна	Эхний улиралд	Авлигатай тэмцэх газраас хийсэн шалгалтын мөрөөр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 37 ажил арга хэмжээг тусгаж, аймгийн Засаг даргаар батлуулан нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудад албан тоотоор хүргүүлэн ажиллаж байна. Зөвлөмжид дурьдагдсан зөрчлийг дахин гаргахгүй, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах талаар зөвлөмж чиглэлийг өгч хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож байна.
2	Холбогдох хэлтэс, агентлагийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцно	Байгууллагууд өөрсдийн төлөвлөгөө батлах Хэрэгжилтийг зохион байгуулсан байх Хэрэгжилтийн үр дүнг тооцох	Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.	Хагас, бүтэн жилдээ	Нутгийн захиргааны бүх шатны байгууллагууд зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж, хагас жилийн байдлаар 16 сум, 1 тосгон, 14 байгууллагаас биелэлтийг ирүүлж, хэрэгжилт 70 хувийн гүйцэтгэлтэй байна.
3	Захиргааны актын эрх зүйн үндэслэлийг хангуулах, хуулиар олгосон эрх хэмжээг зөв хэрэгжүүлнэ	Эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж чиглэл өгөх Захиргааны ерөнхий хуулийг мөрдлөг болгох, хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэх	Захиргааны актын эрх зүйн үндэслэл хангагдаж зөрчилгүй болсон байна.	Жилдээ	Хууль эрх зүйн хэлтсийн лавламжийн санд эхний хагас жилийн байдлаар Хууль зүй дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгэгдэж дугаар авч хэрэгжиж байгаа 98 эрх зүйн акт ирсэнийг лавламжийн санд бүртгэж, Хишиг-Өндөр, Тэшиг, Гурванбулаг, Рашаант сумын ИТХ-аас баталж хэрэгжүүлэх хэм хэмжээний актын төслийг хянаж, зөвлөгөө өгч ажилласан. Мөн аймгийн Засаг даргын 2019 оны эхний хагас жилийн байдлаар нэмэлт өөрчлөлт орсон 32 захирамжийн эх хувьд өөрчлөлт

					<p>хөдөлгөөнийг хийсэн байна. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах үүднээс эрх зүйн үйлчлэл зогссон 2014-2018 онуудад гарсан 18 захирамжийг хүчингүй болгож хөдөлгөөнийг хийлээ. 2019 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг даргын 415 захирамж, 8 сумын 1233 захирамж, тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, эрх зүйн актын хуулийн үндэслэл хангуулах зөвлөмж чиглэлийг өглөө.</p> <p>Булган аймгийн хэмжээнд 2019 онд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх бараа, ажил үйлчилгээг нийлүүлэх 42 гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж дугаар олгон баталгаажуулсан байна.</p>
4	Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл зарцуулалтад хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлнэ	<p>Төсвийн зарцуулалтад хяналт шалгалт хийж, зөвлөмж чиглэл өгөх</p> <p>Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах бодлого барьж төлөвлөх</p> <p>Сумдад хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд хяналт тавих</p> <p>Төсвийн зарцуулалтын талаар иргэдэд зориулсан сургалт мэдээлэл өгөх</p>	Төсвийн хяналт, сайжирч, зөрчилгүй	Хагас, бүтэн жилдээ	<p>Аймгийн Засаг даргын 2019 оны А/03 тоот захирамжаар сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх удирдамжийн дагуу 5 суманд ажиллаж анхаарах асуудлын талаар зөвлөмж, чиглэлийг сумын Засаг дарга нарт хүргүүлжээ. Мөн аймгийн хэмжээнд хэрэгжиж байгаа тусгай сангийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн ба сум хөгжүүлэх сангийн 2011-2018 оны үйл ажиллагаанд Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу зээл сонгон шалгаруулалт, зээлийн эргэн төлөлт, үйл ажиллагааны үр дүнг шалгаж зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хүргүүлсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн орон нутгийн хөгжлийн сан, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр сумдад хэрэгжүүлэхээр эрх шилжсэн төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан журмын хүрээнд баримт бичгийг бүрдүүлэн санхүүжилтийг тухайн суманд шилжүүлж байна. Сумдын орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд улирал бүр хяналт</p>

					тавин, гүйцэтгэлийн тайланг Сангийн яаманд хүргүүлэн ажиллаж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний талаарх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас, мэдээллийн самбар, аймгийн вэб хуудаст тогтмол мэдээлж байна.
5	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг үр дүнтэй хуулийн хүрээнд зохион байгуулна	<p>Техник эдийн засгийн үзүүлэлт, зураг, төсвийн иж бүрдлийг хангуулсан байх</p> <p>Хэрэгжилтийн явцынн хяналтыг сайжруулах</p> <p>Ашиглалтад өгөх гэрээний хугацааг мөрдлөг болгон санхүүжүүлэх</p> <p>Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын хэрэгжлтийг хангуулах</p> <p>Хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажил арга хэмжээний талаар улирал бүр иргэдэд мэдээлэл өгч байх</p>	Төсөл арга хэмжээний үр дүн сайжирч, энэ талаар иргэдэд мэдээлэл хүрсэн байна.	1,2,3 дугаар улиралд	2019 оны эхний 5 сарын байдлаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 41 төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн дагуу 871.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. 16 төсөл, арга хэмжээ гүйцэтгэлийн шатандаа, 25 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан байна. Гэрээнд заасан хугацаа хэтрүүлэн ажлаа гүйцэтгэсэн 2 гүйцэтгэгчээс 2.6 сая төгрөгийг гэрээний дагуу алданги суутган тооцлоо. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын дагуу холбогдох мэргэжлийн байгууллагуудын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, бусад бичиг баримтыг үндэслэн санхүүжилтийг олгож байна. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг улирал бүр гарган шилэн дансны нэгдсэн цахим хуудас, хэлтсийн ил тодын мэдээллийн самбар, аймгийн вэб хуудас зэрэгт байршуулан, иргэд олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна. Худалдан авах ажиллагааны тайлан үр дүнг тухай бүр нь www.tender.gov.mn цахим хуудсаар мэдээлж иргэд олон нийтийг мэдээлэл авах боломжоор ханган ажиллаж байна
6	Худалдан авах ажиллагааны чиглэлээр алба	Чадавхжуулах сургалтыг үр дүнтэй зохион байгуулах	Албан хаагчдийн чадавх сайжирч иргэдийн	Хагас, бүтэн жилдээ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Тогтвортой амьжиргаа-3 төсөлтэй хамтран “АЗ” гэрчилгээ олгох сургалтыг 2 удаа зохион

	хаагчдийг мэргэшүүлнэ	<p>Үнэлгээний хорог байнгын бус ажиллагаатай болгох</p> <p>Иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах боломжийг бүрдүүлэх</p> <p>Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах</p>	оролцоо нэмэгдсэн байнх		байгууллаа. Сургалтад 166 оролцогч хамрагдсанаас 98 оролцогч буюу 60 хувь нь тэнцэж АЗ гэрчилгээ авсан. Мөн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ гэрчилгээ олгох сургалтад аймгийн ИТХ-ын дэргэдэх орон тооны бус иргэний зөвлөлийн 2 ажилтан, 1 иргэн хамрагдаж гэрчилгээ авсан. Худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдийг байнгын бус ажиллагаатай байлгах зорилгоор зарлагдсан төсөл арга хэмжээ, түүний онцлог, цар хүрээ, эрхэлсэн ажил үүрэгтэй нь уялдуулан аймгийн Засаг даргын тамгын газрын бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн, холбогдох агентлагийн шаардлагатай албан тушаалтныг үнэлгээний хороонд оролцуулж байна. Үнэлгээний хороонд Булган сумын АЗ гэрчилгээтэй 5 иргэнээс тойргийн журмаар сонгон ажиллуулж байна.
7	Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалыг хэрэгжүүлэх, хугацаанд нь холбогдох мэдээллийг хүргүүлнэ	<p>Байгууллагуудад журмыг хүргүүлэн зөвлөмж чиглэл өгөх</p> <p>Хуулийн хугацаанд холбогдох мэдээллийг АТГ-т хүргүүлэх</p> <p>Хүний нөөцийн мэргэжилтэд хариуцуулах хэрэгжилтэд хяналт тавих</p> <p>Мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах</p>	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	Тухай бүр	Авлигатай тэмцэх газрын даргын тушаалыг хэрэгжүүлэн мөрдөж ажиллах талаар аймгийн удирдах ажилтаны шуурхай хуралдаанаар танилцуулж чиглэл зөвлөмжийг хүргүүлсэн. 2019 оны эхний хагас жилийн байдлаар ашиг сонирхлыг зөрчил гаргаж албаны давуу байдлаа хэтрүүлсэн Бүрэгхангай сумын Засаг дарга Н.Эрхэмбаяр, Эрүүл мэндийн газрын дарга С.Нарантуяа нарт аймгийн Засаг даргын захирамжаар сахилгын шийтгэл ногдуулж, журмын дагуу олон нийтэд мэдээлсэн. Дээрх сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчдийн талаарх материалыг АТГ-т хүргүүлсэн.
8	Төрийн албанд томилгоог хийхдээ ХАСХУМ хянуулах,	Аливаа томилгоог хийхдээ ХАСУМ хянуулж зөвлөмж	Зөрчил арилж, томилгоо хуулийн дагуу хийгдсэн	Тухай бүр	2019 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг дарга томилдог 6 албан тушаалтаны ХАСУМ-ыг хянуулан томилгоог хийж, хуулийн

	ХАСХОМ хуулийн хугацаанд гаргуулах, сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй явуулнэ	авсны дараа томилгоог хийж хэвших Хуулийн хугацаанд ХАСХОМ гаргахад хяналт тавих Ажлын байрыг ил тод нээлттэйгээр зарлах, хуулийн дагуу томилгоог хийх	байна.		хугацаанд нь хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлсэн байна. Төрийн албаны тухай хууль шинэчлэгдэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан ажлын сул орон тооны сонгон шалгаруулалт зарлаагүй хүлээгдэж байна.
9	Иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх Сургалт, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулах Иргэний нийгмийг чадавхжуулах Хяналт шалгалтад төлөөлөл оролцуулах	Зарим чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж, иргэний хяналт сайжирсан байна	Тухай бүр	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар 53 ажил гүйцэтгүүлэхээр төлөвлөж баталсан бөгөөд 2019 оны 6 дугаар сарын байдлаар 35 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд иргэний танхимаар 89 удаагийн хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулж 3536 иргэнийг хамруулжээ. Мөн 2019 оны худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, хяналт тавиулах үүднээс хяналт шалгалт хийх ажлын урилгыг иргэний байгууллагуудад хүргүүлээд байна.
10	Иргэдэд мэдээллийг хүртээмжтэй хүргэх, ил тод байдлыг хангана	Мэдээллийн шуурхай байдлыг хангах, аймгийн цахим сайтын мэдээллийг байнга шинэчлэх Иргэдтэй уулзах өдөрлөгийг тогтмолжуулах Иргэдэд хүртээмжтэй	Иргэдэд мэдээлэл түргэн шуурхай хүрч, мэдээлэл авах эрх хангагдсан байна.	Тухай бүр	Булган аймгийн албан ёсны www.bulgan.gov.mn сайтын үйл ажиллагааг төрийн байгууллагын вэб сайтад тавигдах MNS 6285-2011 стандартын дагуу ажиллуулж тогтмолжуулан, мэдээллийг шинэчилж, үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг хэрэгцээт мэдээллээр ханган, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, шинэчлэлт, өөрчлөлт, зохион байгуулсан арга хэмжээ, хяналт шалгалт, төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаа, авлигын эсрэг үйл ажиллагаа, өдөр тутмын

		<p>байдлаар мэдээллийг шинэ арга хэлбэрээр хүргэх</p>		<p>мэдээлэл зэрэг нийт 817 дүртэй болон фото, текстэн мэдээ, мэдээллийг тухай бүр оруулж олон нийтэд түгээсэн. Мөн www.bulgan.gov.mn сайтыг Монгол улсын Засгийн газрын www.zasag.mn сайттай холбосон, албан ёсны баяжилт шинэчлэлтийг хийж татвар, улсын бүртгэл, газрын харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн чиглэлийн үйлчилгээ авахдаа бүрдүүлэх материалын дэлгэрэнгүй мэдээллийг тус сайтаас авах боломжтой боллоо. Архи согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл, архивын бичиг баримтын лавлагаа мэдээлэл авахад шаардагдах баримт бичгийн жагсаалтыг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. 2019 оны эхний 6 сарын байдлаар аймгийн вэб сайтад давхардсан тоогоор 417584 хэрэглэгч хандаж төрийн байгууллагын мэдээ мэдээллийг хүлээн авсан байна.</p> <p>Аймгийн Засаг дарга Булган сумын иргэдтэй сар бүрийн 4 дэх 7 хоногийн Пүрэв гарагт уулзалт зохион байгуулж байгаа бол 2019 онд Сэлэнгэ, Рашаант, Гурванбулаг, Хишиг-Өндөр, Орхон, Могод, Баяннуур, Бүрэгхангай, Дашинчилэн, Хутаг-Өндөр, Тэшиг, Баян-Агт суманд ажиллаж орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг сонсон, бодлого, үйл ажиллагаандаа тусган, тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байна. Мөн аймгийн төв Булган сумын багуудын Иргэдийн Нийтийн хуралд оролцон үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан, цаашид хийж хэрэгжүүлэх бодлого чиглэлээ танилцуулж, иргэдийн саналыг сонсож хэвшлээ. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах албанаас “Иргэдээ сонсьё” шууд нэвтрүүлгийг орон нутгийн телевизтэй хамтран 7 хоног бүрийн Пүрэв гарагт бэлтгэн үзэгчдэд 14 дугаар хүргэлээ. Нэвтрүүлгийн зочноор аймгийн</p>
		<p>Иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх</p>		
		<p>Байгууллагын цахим хуудасанд хяналт тавих, үүрэг чиглэл өгөх</p>		

				<p>удирдлагууд, аймгийн Засаг даргын харъяа агентлаг, байгууллага, сумдын дарга мэргэжилтнүүд оролцож, холбогдох асуудлаар тухай бүр хариулт, мэдээлэл өгч, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэн ажиллаж байна. Шууд нэвтрүүлэгтэй холбогдох утас, хэлэлцэх асуудлын мэдээллийг орон нутгийн “Сайхан Монгол” ТВ, “Хөгжлийн хөтөч” сониноор дамжуулан иргэдэд урьдчилан мэдээлж ажиллаж байна. Нэг удаагийн нэвтрүүлэгт дунджаар 8-12 иргэний санал гомдлыг шийдвэрлэж байна. Албан ёсны вэб сайтгүй Баян-Агт, Баяннуур, Бугат, Гурванбулаг, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоныг сайттай болгохоор Үндэсний дата төвд мэдээллээ хүргүүлсэн. Аймгийн нэгдсэн цахим хуудсанд сум, байгууллагын цахим хуудсыг холбож, иргэд олон нийтэд мэдээллийг нэг дороос хялбар авах боломжийг бүрдүүлсэн. Сум, агентлагуудын мэдээллийн ажилтнуудыг нэгтгэсэн мэдээллийн групп нээн мэдээлэл солилцох, түгээх ажлыг хялбарчиллаа.</p>
--	--	--	--	--

Хэрэгжилт гаргасан:

Хууль эрх, зүйн хэлтсийн мэргэжилтэн

Н.Дэлгэрнамжил

Хянасан:

Тамгын газрын дарга

О.Наранжаргал